*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны*
*100 тоот тушаалын 7 дугээр хавсралт*

# ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***ЗОРИЛГО 1. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД*** | | | | | | | |
| *Зорилт 1.1. "Туул усан цогцолбор" төслийг хэрэгжүүлэн үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, гадаргын 125'000 м3/хоног хүчин чадалтай эх үүсвэр барих бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. ( ЗГҮАХ- 1.1.4.7, НЗДҮАХ-7)* | | | | | | | |
| 1.1.1 | "Туул усан цогцолбор төсөл"-ийг барьж байгуулах ажлын зургийн даалгавар боловсруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | Урьдчилсан ТЭЗҮ боловсруулалт хийсэн. | 30 | - 2025 онд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Усны газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хэлэлцээрээр хийгдэж байгаа Туул усан цогцолборын ТЭЗҮ боловсруулах ажлын хэлэлцүүлэгт оролцон санал өгсөн.<br>- Туул усан цогцолборийн ТЭЗҮ боловсруулах санамж бичигт санал хүргүүлсэн. | 100 |
| *Зорилт 1.2. Дулааны II, III цахилгааны станцыг өргөтгөн шинэчлэх, эсхүл дулаан, эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгож, нийслэлд шинээр ашиглалтад орох орон сууцны хорооллыг дулаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. (ЗГҮАХ- 1.1.2.6, НЗДҮАХ-8)* | | | | | | | |
| 1.2.1 | Дулааны II дугаар цахилгаан станцын хүчин чадлыг 300МВт (1 агрегат нь тохируулгын горимд ажиллах хийн генератор бүхий) -аар өргөтгөж, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн ажилд санал өгөх, ажлын зураг зөвшилцөх (300МВт хүчин | - | Ажлын зураг зөвшилцөх, гүйцэтгэлийн хувь | ТЭЗҮ хийгдсэн. | 50 | Тус төсөл нь БГД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт ДЦС-2 ТӨХК-ийн хуучин үнсэн сангийн талбайд нийт 26.4 га газрыг хамран хэрэгжинэ. Төслийн талбайд өртсөн 2ф500мм-ийн голчтой 1.99км урттай үйлдвэрийн уурын шугамын шилжүүлэх дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцөж, ebarilga хот байгуулалтын цахим системд оруулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чадалтай Дулааны 5 цахилгаан станц барих бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх) | | | | | ДЦС-5 станц 300МВт цахилгаан, 340Гкал/цаг-аар нэмэгдсэнээр Нийслэлийн баруун бүсийн эрчим хүч, дулаан хангамжийн хэрэглээг найдвартай хангах боломж бүрдэнэ. | |
| ***ЗОРИЛГО 2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД*** | | | | | | | |
| **Улаанбаатар "20 минутын хот" үзэл баримтлалын дагуу иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| *Зорилт 2.1. Хот байгуулалтын болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд нэгдсэн дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчныг сайжруулна. (ЗГҮАХ -1.1, НЗДҮАХ-ийн – 1.1.1, НЗДҮАХХАХТ-ний – 1.1.1.1)* | | | | | | | |
| 2.1.1 | Улаанбаатар хотын Хот байгуулалтын бүсчлэлийн дүрэмд санал өгөх | - | Саналын тоо | 1 | 1 | Нийслэл хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоосны үндсэн дээр Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг баталж, Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэлийн дүрмийг боловсруулах ажил хийгдэх тул Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа дээрх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэх боломжтой. | 0 |
| 2.1.2 | Хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг холбогдох газарт хүргүүлэх | - | Саналын тоо | - | 1 | - Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулах саналаа (23 заалт) Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2026 оны 01/1045 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Барилгын хөгжлийн төвд салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр 6 хууль, 4 дүрэм, 5 норм ба дүрмийн төсөлд саналаа албан бичгээр хүргүүлсэн.<br>- "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь олон улс, бүс нутаг, гадаад улсын дэвшилтэт стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагад бүртгүүлсний үндсэн дээр хэрэглэж болно" гэж заасны дагуу Олон Улсад ашиглаж буй OIML R 91-1:2025, OIML R 91-2:2025 (Traffic speed camera) стандартыг Монгол Улсад бүртгүүлэн хэрэглэж, ашиглах тухай саналыг Стандарт хэмжилзүйн газарт 2026 оны 01/382 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн дагуу Барилгын стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа MNS EN 14516:2026 стандартын төсөлд саналаа oyungerel.ts@masm.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. | |
| 2.1.3 | Хотын стандартыг хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартад нийцсэн талаарх үзлэг, судалгаа хийх | - | Судалгаа тайлан | - | 1 | - "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-ын 2025 оны 01/762, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2026 оны 01/93 дугаартай албан албан бичгийн дагуу Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага", "Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага" хотын стандартад өөрчлөлт оруулан НИТХ-ын 2026 оны 06 дугаар тогтоолоор батлуулсан.<br>- Нийслэлийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хотын стандарт, салбарын хууль, тогтоомжид нийцэж буй эсэх талаар санал авахаар Нийслэлийн нутгийн захиргааны 12 байгууллага, Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийслэлийн 9 дүүрэгт 2026 оны 01/994 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Албан бичгийн дагуу хотын стандартын хэрэгжилтийн тайланг нэгтгэж байна. | |
| 2.1.4 | Орчны аюулгүй байдлыг хангах, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн Барилга, замын ажил гүйцэтгэх, Хүүхдийн тоглоомын талбай байгуулах, Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд хогийн сав байршуулах, Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлагыг хангасан эхний ээлжийн стандартыг Хот байгуулалтын баримт бичигт тусгаж мөрдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | - 2022-2025 онд батлагдсан 16 бүлгийн 68 хотын стандартыг Эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Багануур үйлдвэрлэл технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Налайх дүүргийн үйлдвэрлэл технологийн паркийн бөөний болон жижиглэн худалдааны төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулах ажлын даалгавруудад тусгуулсан.<br>- 2026.01.20-ны өдөр Дэлхийн банкны Монголд гамшгийн эрсдэлийн менежментийг сайжруулах, хотын гамшгийн эрсдэлийг сөрөн тэсвэрлэх чадавхыг сайжруулах нь төслийн уулзалтад оролцож батлагдсан хотын стандартуудын талаар мэдээлэл өгсөн.<br>- Зураг төсөл зохиогч болон хуулийн этгээдэд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хотын стандартыг барилгын загвар зураг, тохижилтын ажлын загвар зурагт тусгах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| *Зорилт 2.2. Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж батлуулна. (ЗГҮАХ -1.1.1.1, НЗДҮАХ-ийн – 1.1.2, 1.2.3, НЗДҮАХХАХТ -1.1.2.1, 1.1.2.2)* | | | | | | | |
| 2.2.1 | "Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Улсын Их Хуралд өргөн барьж, | - | Төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | "Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах ажлыг зохион байгуулах | | | | | хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсгээс сүүлийн хагас жил чиглэл өгөөгүй байна. | |
| 2.2.2 | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах | Нийслэлийн төсөв 597.5 | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсаны дараа Монгол Улсын Засгийн газарт өргөн барихаар ажиллаж байна. | 0 |
| 2.2.3 | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах (14 хот) | Нийслэлийн төсөв хөрөнгө оруулалтаар 7,728.2 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 30 | 14 хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврын төслийг боловсруулж байгаа бөгөөд холбогдох мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/1483 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тус ажил Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/449 дүгээр захирамжаар хүчингүй болсон. | 90 |
| *Зорилт 2.3. “Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний дагуух хот байгуулалтын бусад баримт бичиг, салбаруудын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. (ЗГҮАХ -1.1.1.1, НЗДҮАХ-ийн – 1.2.1, 1.2.2,1.2.3, 3.3.2, НЗДҮАХХАХТ-1.1.3.4, 1.2.3.1, 1.2.3.2)* | | | | | | | |
| 2.3.1 | Улаанбаатар хотын Ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөөнд Захиалагчийн хяналт тавих | - | Баримт бичгийн тоо | - | 1 | Нийслэл Улаанбаатар хотыг ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөө” боловсруулах ажлын гүйцэтгэгч “Нью Урбанизм” ХХК нь эхлэлийн тайлангийн шатанд иргэд, олон нийтээс дүүрэг хороодоор дамжуулан санал авах ажил хийгдээгүй. Гүйцэтгэгчээс ирүүлсэн эхлэлийн тайлантай тус газар болон Нийслэлийн Орон сууцны бодлогын газар танилцсан. Эхлэлийн тайлангийн тухай 3 талт хамтарсан уулзалт зохион байгуулж, гэрээг дүгнэж цуглахаар шийдвэрлэсэн. | 100 |
| 2.3.2 | Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | Нийслэлийн төсөв 2,078.3 | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1792 дугаар захирамж, 2026 оны А/87 дугаар захирамжийг үндэслэн Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг батлуулж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт 2026 оны 01/153 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тус ажлын гэрээг "Ланд овнер"ХХК-тай 2026.04.13-ны өдрийн НХААГ/20260103045 дугаартай байгуулсан. Тус ажлын эхний шатны тайлан боловсруулалагдаж байна. | |
| 2.3.3 | Агро-сити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулах | ийслэлийн төсө 3,248.0 | Батлагдсан баримт бичгийн тоо | - | 1 | Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа Агросити эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хамт боловсруулсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжийн дагуу "Гоби травел" ХХК болон "Интеллекттауэр" ХХК -ийн түншлэлтэй "Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын НХААГ/20250103049, НХААГ/20250103049-2 гэрээг тус тус байгуулсан. Тус ажлын эхлэлийн болон дундын, эцсийн тайлангуудыг Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Эцсийн шатны тайланг 2026.01.29-ний өдөр Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулдаг Архитектур, хот төлөвлөлтийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2026.03.13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Одоогоор экспертүүд томилогдож, магадлалын нэгдсэн | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгнэлт баталгаажих шатандаа байна. Магадлалын нэгдсэн дүгнэлт баталгаажсаны дараа Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулах ажлыг зохион байгуулна. | |
| 2.3.4 | Дарь-Эх, Монель, Тахилт олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийг батлуулах | Нийслэлийн төсөв 69,0 | Батлагдсан баримт бичгийн тоо | - | 3 | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дүгээр захирамжаар Монел, Тахилт, Дарь-Эх олон нийтийн төвүүдийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) болон барилгажилтын төсөл боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд тус ажлыг “Зураг төсөл консалтинг” ХХК нь гүйцэтгэж байна. Төслийн эцсийн тайланг 2022.06.23-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 22 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. 2025.12.17-ны өдөр магадлалын нэгдсэн дүгнэлт баталгаажсан. Одоо Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ. | 90 |
| 2.3.5 | Иргэд оршин суух газраасаа “20 минутын зайд” алхаж хүрэх ногоон байгууламж бүхий соёл, амралтын хүрээлэн, спортын болон авто зам, нийтийн тээвэр, явган хүний зам, дугуйн зам, явган хүний зам бүхий нэгдсэн цогц төлөвлөлтийг хийж, эрүүл мэнд, боловсрол, худалдаа, үзвэр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд зураг төслийн шатанд санал өгөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | - Нийслэлийн нутаг дэвсгэрт хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 19 удаагийн хурал зохион байгуулж, 500 байршилд загвар инженерийн дэд бүтцийн асуудалд “20 минутын зайд” алхаж хүрэх ногоон байгууламж бүхий соёл, амралтын хүрээлэн, спортын болон авто зам, нийтийн тээвэр, явган хүний зам, дугуйн зам, явган хүний зам бүхий нэгдсэн цогц төлөвлөлтийг тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллав.<br>- Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын дотор алхаж хүрэх боломжтой | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ногоон байгууламж бүхий соёл, амралт, спортын цогц орчныг бүрдүүлэх төлөвлөлтийг дэмжих ажлын хүрээнд Авто зам, замын байгууламж төлөвлөх даалгавар боловсруулан батлуулсан. Үүнд:<br>➢ Явган хүн, унадаг дугуйн гудамж зам – 3 байршилд,<br>➢ Авто зогсоол – 11 байршилд.<br>- Нийслэлийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн зогсоолын менежментийг сайжруулах төсөл арга хэмжээний дагуу ил зогсоол, далд зогсоол, олон давхар болон холимог ашиглалтын зогсоол байгуулах боломжтой байршлын судалгааг нэгтгэн 196 байршилд инженерийн шугам сүлжээний тодруулга гарган, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 07 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэгдэн зогсоол байгуулах байршлуудын жагсаалт батлагдсан. Үүнд:<br>➢ Баянгол – 52 байршил,<br>➢ Баянзүрх - 38 байршил,<br>➢ Сүхбаатар - 43 байршил,<br>➢ Сонгинохайрхан - 7 байршил,<br>➢ Чингэлтэй – 24 байршил,<br>➢ Хан-Уул - 27 байршил,<br>➢ Налайх – 5 байршил.<br>- Дээрх ажлын хүрээнд 5 байршилд гадна дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцсөн. | |
| 2.3.6 | Шинээр байгуулах 14 хотын хөгжлийн бодлогын судалгаанд математик загварчлал боловсруулж, дүн шинжилгээ хийх ажилд санал өгөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 25 | Шинээр байгуулах 14 хотын үндэслэл болох Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэл ирээгүй тул одоогоор санал өгөөгүй. | 0 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.7 | Шинээр байгуулах 14 хот 42 нэгж хороололд орон зайн дүн шинжилгээ хийхэд санал өгөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | 2026.01.20-ны өдөр 14 хотын хилийн цэсийн саналыг боловсруулж, НИХТ-ийн зөвлөлийн хурал болон холбогдох хороодын хурлаар хэлэлцүүлсэн. | 100 |
| *Зорилт 2.4. "Хүннү" хотыг Нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагуул хот болгон хөгжүүлнэ. (НЗДҮАХ-ийн – 1.2.4, НЗДҮАХХАХТ-1.2.4.5, НХТЖҮЧ-5.5.1.2)* | | | | | | | |
| 2.4.1 | Авто замын бүтээн байгуулалтын хүрээнд 127,4 км замын ажлын даалгавар боловсруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Хүннү хотын ажлын алба хариуцаж байна. | - |
| *Зорилт 2.5. Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг хангахад чиглэсэн хотын стандартыг батлан мөрдүүлнэ. (УХТ—1.4.1.1, НЗДҮАХ-ийн – 1.2.11, НЗДҮАХХАХТ-1.2.11.1,1.2.11.2,1.2.11.3)* | | | | | | | |
| 2.5.1 | "Орон сууцны хороолол дахь ногоон байгууламж" хотын стандартын төслийг боловсруулах | - | Хотын стандартын төсөл | - | 1 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт тус ажлын хөрөнгө оруулалтын саналыг тусгуулахаар 2026 оны 01/815 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн болович хөрөнгө шийдвэрлэгдээгүй | 30 |
| 2.5.2 | Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг хангахад чиглэсэн 16 бүлгийн 68 хотын стандартыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлэх | - | Боловсруулсан хэрэгжилтийн тайлан | 1 | 1 | Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж буй төслүүдэд 0301В:2022 “Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага” хотын стандартын хэрэгжилтийг хангах, “Салбарын 100 жил” логотой стикерийг А1 эсхүл түүнээс дээш хэмжээтэйгээр хэвлүүлж, хэрэгжүүлж буй төслийн гадна барилгын хашаанд байршуулах зөвлөмжийг 2026 оны 10/764, 10/769, 10/788 дугаар албан бичгээр нийт 105 иргэн, аж ахуй нэгж байгууллагад хүргүүлж, тайлан авсан. | 100 |
| 2.5.3 | Суурьшлын бүс дэх тэжээвэр амьтдын хотын стандартын төслийг боловсруулах | - | Хотын стандартын төсөл | - | 1 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт тус ажлын хөрөнгө оруулалтын саналыг тусгуулахаар 2026 оны 01/815 дугаартай албан бичгээр санал | 30 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн болович хөрөнгө шийдвэрлэгдээгүй | |
| 2.5.4 | “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулж батлуулахаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах | - | Хотын стандартын төсөл | 1 | 1 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 06/26 тоот тогтоолоор “Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын нэмэлт, өөрчлөлтийг батлуулсан. Тогтоол батлагдсан даруйд хүчин төгөлдөр мөрдөгдөнө. | 100 |
| 2.5.5 | “Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандартад нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулахаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах | - | Хотын стандартын төсөл | 1 | 1 | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны 2026 оны 01/93 дугаар албан албан бичгийн дагуу UCS 1202B:2022 “Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага хотын стандартад нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулсан.<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 85 |
| *Зорилт 2.6. Барилга байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд үнэлгээ хийж, паспортжуулан хүчитгэлийн зураг төслийг боловсруулна. (НЗДҮАХ-ийн – 1.2.15, НЗДҮАХХАХТ-ний 1.2.16.1)* | | | | | | | |
| 2.6.1 | 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах | - | Барилгын тоо | 1023 | 1053 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2026 оны А/99 дүгээр захирамжаар 50 барилга байгууламжид газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг үнэлэх, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах ажилд 200.000.000 /хоёр зуун сая/ төгрөгийг шийдвэрлэсэн. Тус захирамжийн хүрээнд газар хөдлөлтөд эрсдэл бүхий нэн шаардлагатай 23 барилга байгууламжийг паспортжуулахаар төлөвлөж, жагсаалтыг гарган, ажлын даалгавар | 85 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон тендерийн баримт бичгийг бэлтгэн ажиллаж байна. | |
| *Зорилт 2.7. Улаанбаатар хотын газар зүйн мэдээллийн системд суурилсан хот байгуулалтын "Хотын нэгдсэн мэдээллийн дата төв"-ийг байгуулан нээлттэй ашиглана. (НЗДҮАХ-1.2.24, НХТЖҮЧ-7.3.6.2)* | | | | | | | |
| 2.7.1 | eBarilga нийслэлийн хот байгуулалтын цахим системд гурван хэмжээст зураглал, хөгжүүлэлт, тооцоолол хийх, хиймэл оюун ухаанд шилжүүлэх | Нийслэлийн төсөв 181.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/447 дугаар захирамжаар Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2026 онд санхүүжүүлэх тус ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллах эрхийг шилжүүлсэн. Газрын дарга тус ажлын 2026/01 дугаартай ажлын даалгаврыг батлан, Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2026 оны А/61 дүгээр тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдаж, тендерийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Тендерт "Смартдата" ХХК шалгарч, НЗДТГ, "Смартдата" ХХК-тай "eBarilga нийслэлийн хот байгуулалтын цахим системд гурван хэмжээст зураглал, хөгжүүлэлт, тооцоолол хийх, хиймэл оюун ухаанд шилжүүлэх" ажлын гэрээг 2026.11.15-ны өдрийн дотор гүйцэтгэж ашиглалтад оруулахаар байгуулсан. | 85 |
| 2.7.2 | Алслагдсан 3 дүүргийн төвийн хэсгийн 20000 га талбайд 1:1000-ны масштабтай байр зүйн зураглал хийх | Нийслэлийн төсөв 2,311.3 | Зурагжуулах талбай га | - | 20000 га | Хөрөнгө шийдвэрлэгдээгүй. | 0 |
| 2.7.3 | Хот байгуулалтын мэдээллийн сангийн аюулгүй байдал хангах, сервер, компьютерын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх | Нийслэлийн төсөв 525,0 | Шинээр нийлүүлэх тоног төхөөрөмжийн тоо | - | 9 | Хөрөнгө шийдвэрлэгдээгүй. | 0 |
| 2.7.4 | Хот байгуулалтын мэдээллийн санд геодезийн хэмжилтийн багаж тоног төхөөрөмжеэр | Нийслэлийн төсөв 180.0 | Шинээр нийлүүлэх тоног | - | 2 | Газрын дарга "Хот байгуулалтын тоног төхөөрөмж"-ийн техникийн тодорхойлолтыг 2026/02 дугаартай | 85 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах (нисгэгчгүй нисэх төхөөрөмж-1, долгионы GPS иж бүрдэл -1) | | төхөөрөмжийн тоо | | | баталсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2026 оны А/61 дүгээр тушаалаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдаж, тендерийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Тендерт "Ай Ти Скайвишн Ворлд" ХХК шалгарч, хот байгуулалтын тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлын гэрээг НЗДТГ, Ай ти скайвишн ворлд ХХК -тай 2026.07.28-ны өдрийн дотор гүйцэтгэхээр байгуулсан. | |
| 2.7.5 | Хот байгуулалт, төлөвлөлтийн мэдээллийн сангийн орон зайн өгөгдлийг Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт MNS 6702:2017, Газар зүйн мэдээлэл MNS 6925:2021 стандарт руу хөрвүүлэх, мэдээллийг шинэчлэх, үнэн зөв байдлыг хангах | - | Мэдээллийн сангийн хөгжүүлэлт хийх ажлын явц, хувь | - | 50 | Хот байгуулалт, төлөвлөлтийн мэдээллийн сангийн орон зайн өгөгдлийг Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт MNS 6702:2017, Газар зүйн мэдээлэл MNS 6925:2021 стандартад хөрвүүлэх, мэдээллийг шинэчлэх, үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна. | 85 |
| *Зорилт 2.8. Хот байгуулалтын мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг баяжуулан мэдээллийн сангийн найдвартай ажиллагааг хангана. (АХ-9.3.1, НЗДҮАХХААТ-ний – 6.1.3)* | | | | | | | |
| 2.8.1 | Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг хийх. | Нийслэлийн төсөв 2,311.3 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 70 | 30 | Тус ажлын үлдэгдэл санхүүжилт нь 2026 оны төсөвт шилжиж, батлагдсан. Ажлын гэрээний хугацааг 2026.02.10-2026.09.30-ны өдрийг хүртэл НХААГ/20240103238-3 дугаартайгаар сунгасан. Ажлын явцтай танилцан зураглалын явц, байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт MNS 6702:2017, MNS 6925:2021 стандартуудыг мөрдлөг болгон ажиллах, стандартад хөрвүүлэх талаар зөвлөмж өгсөн. Хотын төвийн Нарны зам дагуу байрлах 1.5 км зурвас орчмын байр зүйн зураглал, ортофото зургийг урьдчилсан байдлаар ирүүлснийг шалгахад | 80 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байрзүйн зураглал стандартын дагуу бус, тодруулгын хэмжилт хийгдээгүй, байрзүйн зурагт шат, довжоо болон барилгын орц гарц дутуу зурагдсан, барилга байгууламжийн давхрын мэдээлэл дутуу мэдээллийн сан үүсгэсэн байсан тул ажлын зургийн даалгаварт заасан шаардлагын дагуу зөвлөгөө өгч, зургийг буцаан засварлуулж байна. | |
| *Зорилт 2.9. Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дижитал твин загварчлалаар Улаанбаатар хотын гурван хэмжээст дүрслэл (3d virtual)-ийн хөгжүүлэлт, тооцоолол (simulation)-ыг боловсруулж, үе шаттай хөгжүүлэх* | | | | | | | |
| 2.9.1 | Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг дижитал твин загварчлалаар Улаанбаатар хотын гурван хэмжээст дүрслэл (3d virtual)-ийн хөгжүүлэлт, тооцоолол (simulation)-ыг боловсруулж, хэрэглээнд нэвтрүүлэх | Нийслэлийн төсөв 5,950.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 50 | 50 | - 1-р үе шатны дэлгэрэнгүй тайланг 2026.01.10-ны өдөр elizabeth.burgnen@skyral.io цахим шуудангаар хүлээн авсан. Гэрээнд заагдсан нийт 1,700,000.00 (нэг сая долоон зуун мянга) ам доллар буюу 5,950,000,000.00 (таван тэрбум есөн зуун тавин сая) төгрөгийг Annex H гэрээний заалтад заасны дагуу 1 дүгээр үе шатны гүйцэтгэлийн төлбөр 50% 2,974,920,000.00 (хоёр тэрбум есөн зуун далан дөрвөн сая есөн зуун хорин мянга) төгрөгийн санхүүжилт олгогдсон.<br>- 2-р үе шатны ажлын тайланг 2026.03.10-ны өдөр elizabeth.burgnen@skyral.io цахим шуудангаар хүлээн авсан. Тус тайлангийн явцад 6-8 ажлын үр дүнг танилцуулсан.<br>Ажлын гүйцэтгэлийг бүрэн хүлээн авч, 3 хэрэглэгчийн нэвтрэх эрхийг авч туршилт, дүн шинжилгээ, симуляци хийж нэмэлт хөгжүүлэлт хийх, сайжруулах санал хүргүүлэхийг ажлын хэсэгт даалгасан. | 70 |
| *Зорилт 2.10. Улаанбаатар дэд станцын хүчин чадлыг 2х200 МВА болгон тоноглон шинэчлэх, Парк, Дамбадаржаа, Баянхошуу, Их наран дэд станц, 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж дамжуулах сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ. (НЗДҮАХ-ийн – 1.3.2, НЗДҮАХХААТ-ний – 1.2.3.3, 3.1.7.1)* | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.10.1 | Дамбадаржаа, Баянхошуу, Их наран, 110/35/10кВ-ын 2*40МВА чадалтай дэд станц, 110кВ-ын ЦДАШ-ын газар олголтыг шийдвэрлэх, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | - Дамбадаржаа дэд төв, Сэлбэ дэд төвийн цахилгаан хангамжийн ажлын хүрээнд 110/35/10кВ-ын Дамбадаржаа дэд станцын 17,9 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт санал хүргүүлснээс 2025 онд 5,9 тэрбум, 2026 онд 2.0 тэрбум төгрөг батлагдсан. Дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр ДМТМ трейд ХХК шалгарч, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус дэд станцын газар олголтыг өөрчлөх саналыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Дамбадаржаа дэд станцын ажлын зураг төслийг зөвшилцөн хот байгуулалтын ebarilga цахим системд оруулсан.<br>- Шинээр төлөвлөж буй 110/35/10 кВ Баянхошуу, Их наран дэд станцын барилга угсралтын ажлын төсвийг Улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлсэн бөгөөд хөрөнгө шийдвэрлэгдээгүй Ажлын зураг төслийг зөвшилцөн хот байгуулалтын ebarilga цахим системд оруулсан. | 100 |
| 2.10.2 | Парк 110/10кВ-ын 2*63МВА чадалтай дэд станц, 110кВ-ын ЦДАШ, ЦДКШ-ын газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төсөл зөвшилцөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/48 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын төвийн хэсгийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах зорилгоор СБД-ийн 1-р хорооны нутаг дэвсгэрт НЗДТГ-ын эзэмшлийн 10.2 га талбайд цахилгааны дэд станц өргөтгөн барихтай холбогдуулан Эрчим хүчний яамны харьяа "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн эзэмшиж буй 0.089 га газрын талбайн хэмжээг нэмэгдүүлж, 0.12 га хэмжээтэйгээр | 85 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөсөн байршилд 110/10кВ-н Парк /Өргөө болж нэр солигдсон/ дэд станцын газрын асуудлыг шийдвэрлүүлсэн. Дэд станцын 110кВ-ын кабель шугамын трассыг Бохир усны Туул коллекторын трасстай уялдуулж, шийдэл гаргахаар ЦДҮС ТӨХК болон Зураг төсөл зохиогч Бодит чадал ХХК судалгаа хийж байна. | |
| 2.10.3 | Шинээр баригдах дэд станцуудын ажлын зургийн даалгавар боловсруулах, ажлын зураг төсөл зөвшилцөх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах.(13 багц) | Нийслэлийн төсөв 2,853.6 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Дэд станцын зураг, төсвийн гүйцэтгэгч шалгарсан бөгөөд төлөвлөж буй болон өргөтгөх шаардлагатай дэд станцын газар олголт, цахилгаан түгээх шугамын трассыг чөлөөлүүлэхээр ЦДҮС ТӨХК-тэй хамтарч судалсны дагуу Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд газар олголтыг шийдвэрлүүлэхээр 2025 оны 02/519 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 70 |
| *Зорилт 2.11. Цахилгаан хангамжийн түгээх сүлжээг шинэчилж, шинээр хуваарилах байгууламж, дэд өртөө барьж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр хангана. (НЗДҮАХ-ийн – 1.3.3, НЗДҮАХХААТ-ний – 1.3.3.1)* | | | | | | | |
| 2.11.1 | 35кВ-ын 11 дэд станцын ажлын зураг төсөл зөвшилцөх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 30 | 35/10кВ-ын Хадат дэд станцын барилга угсралтын ажилд "Техникийн цогц шийдэл" ХХК шалгарч, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. | 100 |
| *Зорилт 2.12. Дулаан хангамжийн гол болон орон сууцны хорооллын төвлөрсөн шугам сүлжээ, насос станцыг өргөтгөн шинэчилж, шинээр барьж хүртээмжийг нэмэгдүүлнэ. ( ЗГҮАХ-1.1.2.1, НЗДҮАХ-ийн – 1.3.5, НЗДҮАХХААТ-ний – 1.3.5.3 )* | | | | | | | |
| 2.12.1 | Дулааны шугамын өөрчлөлт, шинэчлэлтийн ажлын газар олголтыг шийдвэрлүүлэх, шугамыг хот байгуулалтын мэдээллийн санд тусгах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх /2Ф700/2Ф600/350 мм-ийн голчтой 1.452км шугамын | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | - Дулааны шугамын өөрчлөлт, шинэчлэлт, 9ж-11и магистралийн холбоосын өргөтгөн шинэчлэх 350 хос.метр ажилд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн 2026 оны төсөвт тусгуулахаар саналаа 01/806 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хөрөнгө шийдвэрлэгдээгүй.<br>- Улсын төсвийн 2027 оны саналаа 3д магистраль, 745 м хос шугам солих | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | барилга угсралтын ажил хийгдэнэ/. | | | | | ажлын 4,640.7 сая төгрөгийг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн. | |
| *Зорилт 2.13. Сэлбэ болон Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын хүрээнд хийн түлшний 93МВт хүчин чадал бүхий дулааны станцыг төвлөрсөн сүлжээтэй хосолмол ажиллагаатай нөхцөлөөр ашиглалтад оруулж, орон сууцны 7 дугаар хороолол болон Дэнжийн мянга дэд төвийн дулаан хангамжийг шийдвэрлэнэ. ( ЗГҮАХ-1.1.2.1, НЗДҮАХ-ийн – 1.3.6)* | | | | | | | |
| 2.13.1 | Дэнжийн мянга дэд төвийн 93МВт-ийн хийн түлшний дулааны эх үүсврийн газар олголтыг шийдвэрлүүлэх, ажлын зураг төслийг зөвшилцөх, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 25 | - Сүхбаатар дүүргийн 9-р хороо, Ногоон нуурын хойд талд цахилгаан, эрчим хүчний барилга байгууламжийн зориулалтаар 2.0 га газар Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-ийн эзэмшилд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1605 дугаар захирамжаар олгогдсон. Тархмал эх үүсвэрийн ТЭЗҮ-ийн гүйцэтгэх гэрээ 2026.04.30-ны өдөр хийгдсэн. Тус ажлын гүйцэтгэл-20%-тай байна. Дулааны эх үүсвэрийн загвар зураг боловсруулагдаж байна. Дулааны эх үүсвэрийг Тармал эрчим хүчний дэд бүтэц ХХК хариуцан гүйцэтгэж, ТЭЗҮ боловсруулж байна.<br>- Дэнжийн мянга дэд төвийн 93МВт-ийн хийн түлшний дулааны эх үүсвэр барьж ашиглалтад оруулахад нийт 255,660.0 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатайгаас Нийслэлийн 2026 оны төсөвт 127,830.0 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлүүлэхээр саналаа НЗДТГ-т албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 2.13.2 | Дамбадаржаа 63МВт-ын дулааны станцын ажлын зураг төсөл зөвшилцөж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 15 | 35 | "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороонд хэрэгжиж байгаа дулааны станцын гүйцэтгэгч "China Second Metallrugy Group Co., Ltd" барилга угсралтын ажил 50 хувьтай хийгдэж байна. | 100 |
| 2.13.3 | Сэлбэ дэд төвийн 63МВт-ын дулааны станцын ажлын зураг | - | Үйл ажиллагааны | 15 | 15 | - "Сэлбэ дэд төв" барилгажилтын төслийн дулаан хангамжийн ажлын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөл зөвшилцөж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлүүлэх саналыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх, хот байгуулалтын мэдээллийн санд тусгах | | хэрэгжилтийн хувь | | | зургийг зөвшилцөн, хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. Тус ажлын зурагт шинээр төлөвлөж буй Сэлбэ дэд төвийн 63МВт-ын дулааны эх үүсвэрийн гадна дулааны шугамыг зөвшилцөж, хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан.<br>- Сэлбэ дэд төвийн дулаан хангамжийн эх үүсвэрийг төлөвлөх, зохион байгуулах ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/763 дугаар захирамжаар баталсан. 2026.05.28-ны өдөр ажлын хэсгийн гишүүдэд Сэлбэ дэд төвийн дулаан хангамжийн асуудлаар танилцуулга бэлтгэн танилцуулсан. | |
| *Зорилт 2.14. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн тархмал эх үүсвэр болон алслагдсан суурьшлын бүсүүдэд дулааны станцуудыг үе шаттайгаар барина. ( ЗГҮАХ-1.1.2.1,НЗДҮАХ-ийн – 1.3.7, НЗДҮАХХААТ-ний – 1.3.7.5)* | | | | | | | |
| 2.14.1 | Яармаг хотын шинэ төвд 93МВт-ийн дэвшилтэт технологи бүхий дулааны эх үүсвэрийн газар олголтыг шийдвэрлүүлж, ажлын даалгавар боловсруулах, ТЭЗҮ, ажлын зураг төсөл зөвшилцөх, | Нийслэлийн төсөв 750.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Тус төслийн нийт санхүүжилтийг Улс, нийслэл, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжаар шийдвэрлэхээр тусгасан. ХУД-ийн 8 дугаар хороонд төвлөрсөн сүлжээтэй хосолмол ажиллагаатай 93 МВт-ын эх үүсвэр барихад шаардлагатай 3.5 га газар шаардлагатай тул газар олголтын асуудлыг яаралтай шийдвэрлэж өгөх тухай 2026 оны 02/335 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 70 |
| *Зорилт 2.15. Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг барьж, дулааны хүчин чадлыг 216.МВт-аар нэмэгдүүлэх төсөлд дэмжлэг үзүүлнэ ( ЗГҮАХ-1.1.2.10, НЗДҮАХ-ийн – 1.3.8, НЗДҮАХХААТ-ний – 1.3.8.1)* | | | | | | | |
| 2.15.1 | Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг барьж дулааны хүчин чадлыг 116 МВт-аар нэмэгдүүлэхэд санал өгөх | - | Саналын тоо | - | 1 | Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг барьж 116 МВт-аар нэмэгдүүлэх төслийн эхний ээлжийн 79МВт-ын ажлын зураг төсөлд 1,3 тэрбум төгрөгийг Нийслэлийн 2026 оны төсөвт тусгуулан хөрөнгө шийдвэрлэгдсэн. Тус эх үүсвэрийн хүрээнд 2ф700мм-ийн 6.02км дулааны шугамын ажлын зураг төслийг | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвшилцөж, хот байгуулалтын ebarilga цахим системд оруулсан. | |
| *Зорилт 2.16. Хийн түлшний эх үүсвэрээр ажиллах дулааны хэсэгчилсэн эх үүсвэр барих, одоо ашиглагдаж байгаа уурын зуухнуудыг хийн түлшний эх үүсвэрт шилжүүлэх, гэр хорооллын утаагүй шахмал түлшний хэрэглээг үе шаттайгаар хийн түлшинд шилжүүлэх замаар дулаан хангамжийг шийдвэрлэж агаарын бохирдлыг бууруулна. ( ЗГҮАХ-1.1.2.10, НЗДҮАХ-ийн – 1.3.9)* | | | | | | | |
| 2.16.1 | Хийн түлшний эх үүсвэрээр ажиллах дулааны хэсэгчилсэн эх үүсвэр барих, одоо ашиглагдаж байгаа уурын зуухнуудыг хийн түлшний эх үүсвэрт шилжүүлэх ажлын хүрээнд төлөвлөлтийн шийдэлд санал өгөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Дэнжийн мянга 93 МВт дулааны хийн эх үүсвэрийн хамгаалалтын зурвасыг хот байгуулалтын мэдээллийн санд шинэчлэн оруулсан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны захиалгаар БЗД 27 дугаар хороонд даралтат далд савнаас шингэрүүлсэн нефтийн хийгээр 50 айл өрхийг халаах хийн халаалтын зуухыг нэгдсэн шугамаар холбох төслийг Дашваанжил групп ХХК хэрэгжүүлж архитектур төлөвлөлтийн даалгавар болон цахилгаан хангамжийн зураг төсөл батлагдсан. | 100 |
| *Зорилт 2.17. Үерийн эрсдэлийн хохирлын үнэлгээг боловсруулж, голуудын эргийн хамгаалалт 30 км далан, 100 км суваг, 4 байршилд усан сан, хөв, цөөрөм, 20 км хөрсний ус зайлуулах шугам сүлжээг барьж байгуулан үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. (ЗГҮАХ-1.1.4.6, НЗДҮАХ-ийн – 1.3.10, НЗДҮАХХААТ-ний – 1.3.10.4, 1.3.10.5)* | | | | | | | |
| 2.17.1 | "Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд хийгдэж байгаа ажлын даалгавар боловсруулах | - | Ажлын зураг зөвшилцөх хэрэгжилтийн хувь (12 багц) | 10 | 30 | - Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдэх албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 12 хурлаар хэлэлцүүлж, батлуулан Захиалагч байгууллагад 24 ажлын зургийн даалгаврыг хүргүүлсэн. Үүнд:<br>➢ Үерийн далан сувгийн 15 байршил<br>➢ борооны усны шугамын 6 байршил<br>➢ хөрсний усны шугамын 3 байршил<br>- Чингэлтэй дүүрэг Хайлаастын гудамжны үерийн далан сувгийн ажлын зургийн даалгаврыг батлуулан захиалагчид хүргүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.17.2 | Нарангийн голын эргийн хамгаалалтын далан, сувгийг барьж ашиглалтад оруулахад ажлын зураг зөвшилцөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Туул, Сэлбэ голын эргийн хамгаалалтын ТЭЗҮ–ийн зураг төсөл зөвшилцсөн. Нийт үерийн далан борооны ус, хөрсний усны шугамын 20 ажлын зураг төсөл зөвшилцөж, хот байгуулалтын ebarilga цахим системд оруулсан. | 70 |
| 2.17.3 | Шинээр баригдах үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлын зураг зөвшилцөн, хот байгуулалтын мэдээллийн санд оруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 50 | Үерийн далан сувгийн 11 ажлын зургийн даалгавар боловсруулж, захиалагчид хүргүүлсэн. Үүнд:<br>➢ ЧД-ийн 2 байршил,<br>➢ СХД-ийн 4 байршил,<br>➢ ХУД -ийн 4 байршил,<br>➢ СБД- ийн 1 байршил. | 100 |
| *Зорилт 2.18. Шинээр болон өргөтгөн шинэчлэх 257 км авто зам, замын байгууламжийг ус зайлуулах сүлжээтэй барьж байгуулан усанд автдаг байршлуудын тоог бууруулна. (НЗДҮАХ-ийн – 1.3.11, НХТ)* | | | | | | | |
| 2.18.1 | Туул голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийг үерийн эрсдэл өндөр болон Туул хурдны замын трасстай давхцсан хэсгүүдэд ажлын зураг зөвшилцөн хот байгуулалтын мэдээлллийн санд оруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 10 | 50 | - Туулын хурдны замын трасст Туул голын хойд эргийн дагуух 18.0км үерийн далан сувагтай давхцаж байгаа бөгөөд хурдны замын ажлын зурагт тусгагдсан.<br>- Туул хурдны зам, Туул голын үерийн далангийн давхацсан хэсгүүдийн мэдээллийг бэлтгэж ХББОСС-ын 2026 оны 100 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаанд үерийн далан сувгийн одоогийн байдал төлөвлөлтийн мэдээллийг танилцуулсан. | 100 |
| *Зорилт 2.19. Ус хангамжийн шугам сүлжээг нэмэгдүүлэх, шинээр 4, төвлөрөл их 6 байршлын усан сан өргөтгөх замаар хүртээмжийг нэмэгдүүлнэ. (НЗДҮАХ-ийн – 1.3.15, НЗДҮАХХААТ-ний – 1.3.15.1, 1.3.15.3,1.3.15.4)* | | | | | | | |
| 2.19.1 | Хужирбулан, Жаргалант, 361-н гарам, Тахилт, Зайсан, Залуус-1, Буянт-Ухаа-2 хороолол орчим усан сан, шугам сүлжээний ажлын даалгавар боловсруулж, ажлын зураг зөвшилцөн хот байгуулалтын мэдээлллийн санд оруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 30 | 25 | Нийслэлийн 2026 оны төсвийн хөрөнгөөр Хужир булангийн усан сан, цэвэр усны шугамын ажлын зураг, ажлын зураг төсөл боловсруулах хөрөнгө шийдвэрлэгдсэн. Тус шугамын ажлын зургийн даалгаврыг батлуулан захиалагч байгууллагад хүргүүлсэн. | 100 |
| 2.19.2 | Толгойт, Их наран, 3,4-р хорооллын гэр хороолол, Шинэ | - | Үйл ажиллагааны | 30 | 25 | Нийслэлийн 2026 оны төсвийн хөрөнгөөр Шинэ Ярмагийн цагариг ус хангамжийн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Яармаг, Дэлгэрэх хотхон орчим шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөн хот байгуулалтын мэдээлллийн санд оруулах | | хэрэгжилтийн хувь | | | шугамын ажлын зураг төсөл боловсруулах хөрөнгө шийдвэрлэгдсэн. Тус шугамын ажлын зургийн даалгаврыг батлуулан захиалагч байгууллагад хүргүүлсэн. | |
| 2.19.3 | Зүүн хойд, Завсар, Хайлааст, Нисэх, Баруун дүүргийн усан санг өргөтгөж, дамжуулах 11.5 км урт шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөн хот байгуулалтын мэдээлллийн санд оруулах | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 3,685.5 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 10 | 15 | Зүүн хойд бүсийн усан сангийн өргөтгөлийн ажилд нийслэлийн 2026 оны төсвийн хөрөнгөөр санхүүжилт шийдвэрлэгдсэн, барилга угсралтын ажилд нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Ажлын зураг төсөл зөвшилцсөн. | 100 |
| *Зорилт 2.20. Улаанбаатар хотын Шинэ төв цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, Морингийн цэвэрлэх байгууламжийг өргөтгөх ажлыг эхлүүлэн хот бүрд зөөврийн бохир ус “Юүлэх станц” барьж цэвэрлэх байгууламжуудын найдвартай ажиллагааг хангана. (НЗДҮАХ-ийн – 1.3.18, НЗДҮАХХААТ-ний – 1.3.15.1, НЗДҮАХХААТ-ний – 1.3.15.4)* | | | | | | | |
| 2.20.1. | "Морингийн даваaны Цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төсөл"-ийн ажлын даалгавар боловсруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 15 | Улаанбаатар хотын Шинэ төв цэвэрлэх байгууламжийн ажил дуусан улсын комисс хүлээн авч байна. Тэрээр хоногт 250000 м3 усыг цэвэршүүлэх хүчин чадалтай. Морингийн даваaны цэвэрлэх байгууламжийн юүлэх станцын зураг төсөл хийгдсэн. Гаргалгааны сувгийн засвар шинэчлэлтийн ажлыг Ус сувгийн удирдах газар хийж байна | 100 |
| *Зорилт 2.21. Дагуул хот, гэр хорооллын бүсэд хэсэгчилсэн цэвэрлэх байгууламж, шугам сүлжээг барьж, Туул-1, Толгойт, Орбит, Цайз зэрэг коллектруудыг ашиглалтад оруулж, Улаанбаатар хотын Бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ. (НЗДҮАХ-ийн – 1.3.20, НЗДҮАХХААТ-ний – 1.3.20.1, 1.3.20.2)* | | | | | | | |
| 2.21.1. | Хүннү, Багануур, Агросити хотын цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх ажлын зураг зөвшилцөх | Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт 10,000.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 35 | Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эхлэлийн, дундын, эцсийн тайлан, зураглалын материалд санал өгч, зөвшилцсөн. | 100 |
